Төрийн албаны зөвлөлийн
2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн
121 дүгээр тогтоолын 02 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☑ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| Нийслэлийн нийгмийн даатгалын газар | Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
| Хяналт шалгалт, дотоод аудит хариуцсан ахлах байцаагч | Дэс түшмэл, ТЗ-6 |
| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын өдрийн 8 цаг | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо Бага тойруу 13/1 |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нийгмийн даатгалын сангийн төсөв, түүний гүйцэтгэлд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

**Албан тушаалын зорилт:**

1.Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, салбарын үйл ажиллагаанд санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит хийх, тайлагнах.
2.Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавьж зөвлөгөө мэдээллээр хангах.
3.Байгууллагын болон нэгжийн дотоод зохион байгуулалтыг хангаж, хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах–Х Шийдвэрлэх –Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудад Нийгмийн даатгалын чиглэлээр санал өгөх, хэрэгжүүлэх; | Үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Г, Х |
| | 2.Тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хүрээнд чиг үүргийн дагуу санал өгөх, хэрэгжүүлэх; | Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байна. | Г, Х |
| | 3.Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хяналт, шалгалтыг сайжруулах чиглэлээр заавар зөвлөмжийн санал өгөх хэрэгжүүлэх; | Хууль, тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна. | Г,Х |
| | 4.Байгууллагын чиг үүрэгтэй хамааралтай тогтоол, шийдвэр, зөвлөмж, үүрэг даалгаврын заалтуудын хэрэгжилтийн мэдээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах; | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журмын хэрэгжилтэд нийцсэн байна | Г,Х |
| | 5.Хяналт шалгалтын байцаагч нарын ур чадварыг дээшлүүлэх ажил зохион байгуулах; | Хяналт шалгалтын байцаагч нарын мэдлэг чадвар дээшилсэн байна. | Г, Х |
| | 6.Газар, хэлтсийн хариуцсан асуудлын хүрээнд хяналт шинжилгээ үнэлгээ, аудит хийх; | Газар, хэлтсийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан шинжилгээ үнэлгээ хийгдсэн | Г, Х |

| | | | |
|---|---|---|---|
| | | байна. | |
| | 7.Хяналт шалгалтын байцаагч нарыг шинжилгээ үнэлгээ хийх арга зүйгээр хангаж ажиллах; | Хяналт шалгалтын байцаагч нарын шинжилгээ үнэлгээ хийх чадвар дээшилсэн байна. | Г, Х |
| | 8.Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө тайлан мэдээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах; | Байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журмын хэрэгжилтэд нийцсэн байна. | Г, Х |
| | 9.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, засгийн газрын тогтоолын биелэлтэд хяналт тавих, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах. | Байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журмын хэрэгжилтэд нийцсэн байна. | Г, Х |
| | 1.Нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудад шалгах, хяналт тавих; | Хяналт шалгалтын ажил чанартай, үр дүнтэй, хуулийн дагуу хийгдсэн байна. | Г, Ш |
| | 2.Хяналт шалгалтын ажилд үнэлгээ шинжилгээ хийж, үр дүнг тооцож, хуулиудыг нэг мөр, үнэн зөв хэрэгжүүлэх; | Шинжилгээ хийж үр дүнг тооцсон байна. | Г, Ш |
| | 3.Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, төлбөрийн дүн мэдээтэй танилцаж, барагдуулалтад хяналт тавих; | Хяналт тавьж төлбөр бүрэн барагдсан байна | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 4.Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах; | Улсын байцаагчийн актаар тогтоогдсон төлбөр бүрэн барагдсан байна. | Г, Х |
| | 5.Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчилд улсын байцаагчийн акт тогтоох, актын бүртгэл хөтлөх; | Хууль, тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна. | Г, Х |
| | 6.Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын дотоодын болон хөндлөнгийн, дээд шатны байгууллагаас хийсэн хяналт шалгалтын тайлан мэдээтэй танилцаж, үр дүнг тооцон ажиллах; | Дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн ажил сайжирсан байна. | Г, Х |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 7.Улсын байцаагчийн гаргасан акт, дүгнэлт, албан шаардлагыг хянаж үзэх, мэргэжилтнүүдийн үйл ажиллагаа болон хяналт шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх; | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна. | Г, Х |
| | 8.Хяналт шалгалтын ажилд үнэлгээ шинжилгээ хийж, үр дүнг тооцох. | Хяналт шалгалтын ажлын чанар сайжирч, нийгмийн даатгалын хуулиудын хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Төрийн албаны тухай хууль түүнтэй нийцүүлэн гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах; | Хууль, тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна. | Г |
| | 2.Үйл ажиллагааны болон Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, ажлын үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлүүлэх, тайлагнах; | Хууль тогтоомжид заасан хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. | Г |
| | 3.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм болон холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллах; | Холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажилласан байна. | Г |
| | 4.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, биелэлтийг хангах, тайлагнах; | Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна. | Г |
| | 5.Өргөдөл, гомдол, санал, албан бичигт хариу өгөх; | Хуулийн хугацаанд хариу өгч шийдвэрлэсэн байна. | Г |
| | 6.Ажлын чиг үүрэгтэй холбоотой судалгаа, мэдээ, тайлан гаргах; | Тухай бүр гаргасан байна. | Г |
| | 7.Албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллах; | Заавар, стандартыг мөрдөж ажилласан байна. | Г |
| | 8.Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт хүлээлгэн өгөх; | Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байна. | Г |
| | 9.Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах; | Ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байна. | Г |

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ... ДОВШООРОВ

| | | | |
|---|---|---|---|
| | 10.Ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажиллах үүрэг хүлээх; | Мэдээллийн нууц алдагдаагүй байна. | Г |
| | 11.Олон нийтийн арга хэмжээнд оролцох, зохион байгуулах; | Зохион байгуулагдсан ажилд идэвхтэй оролцсон байна. | Г |
| | 12.Ажлын цагийг баримтлах, цаг ашиглалтыг сайжруулах; | Ажлын цаг ашиглалт сайжирсан байна. | Г |
| | 13.Ажлын байранд дүрэмт хувцсыг журамд заасны дагуу өмсөж ажиллах; | Дүрэмт хувцсыг өмсөж хэвшсэн байна. | Г |
| | 14.Цаг үеийн шинж чанартай бусад үйл ажиллагаанд оролцох, хэрэгжилтийг ханган ажиллах. | Тухай бүр оролцсон байна. | Г |

## III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| Мэргэжил | -нягтлан бодох бүртгэл /0.4110.1/;<br>-санхүү /0.4120.1/;<br>-даатгал /0.4120.2/;<br>-эдийн засаг/0.3110.1/;<br>-бизнесийн удирдлага/0.4130.1/;<br>-эрх зүй/042/. | |
| Мэргэшил | Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх. | |
| Туршлага | Нийгмийн даатгалын салбарт туслах эсхүл дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх. | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - нийгмийн даатгалын салбарын чиглэлээр мэдээлэл цуглуулах, мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;<br>- бодлогын судалгааны чанарын болон тоон аргыг ашиглан дүн шинжилгээ хийх;<br>- нийгмийн даатгалын салбарын чиглэлээр хариуцан гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх;<br>- нийгмийн даатгалын салбарын асуудлын хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;<br>- нийгмийн даатгалын салбарын асуудлаар судалгаа хийж дүнг хариуцах;<br>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид |

МОНГОЛ УЛС ... ЗӨВЛӨЛ ... ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨ...

| | | |
|---|---|---|
| | | шийдвэрлэх;<br>- саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;<br>- бусад. |
| | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах;<br>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;<br>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, хувийн зан төлөв, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, зарчимч, тууштай байх,<br>- ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг үлгэрлэх;<br>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;<br>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;<br>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;<br>- бусад. |
| | Бусад | - байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдөж, ажиллах;<br>- чанарын менежментийн тогтолцоо, стандартчилалыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх;<br>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;<br>- англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх;<br>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технилоги ашиглах чадвартай байх;<br>- нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхтэй байх. |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хэлтсийн дарга.

| | |
|---|---|
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br><br>Хяналт шалгалтын байцаагч<br><br>Нийт .... | Бусад харилцах субъект<br>1.Төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах;<br>2.Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай харилцах;<br>3.Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага. |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| | |
|---|---|
| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |

ЗӨВШӨӨРӨВ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

<table>
<tr>
<td><u>Албан тушаал</u>:<br>НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА<br>.................................... О.БАЙГАЛМАА<br>20… оны … сарын … -ны өдөр</td>
<td><u>Байгууллагын нэр</u>:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br><u>Шийдвэрийн огноо</u>: 20 04 01<br><u>Дугаар</u>: 121</td>
</tr>
<tr>
<td colspan="2">Албан тушаалын тодорхойлолт баталсан:</td>
</tr>
<tr>
<td colspan="2"><u>Байгууллагын нэр</u>:<br>НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР<br><u>Шийдвэрийн огноо</u>: ........................................<br><u>Дугаар</u>: ......................<br>(тамга/тэмдэг)<br>ДАРГА ........................................................ /Г.БОЛОРСҮХ/<br>20… оны … дугаар сарын … -ны өдөр</td>
</tr>
</table>

МОНГОЛ УЛС
ЗОВШООРОВ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ